

### CLB гэж юу вэ?

CLB нь сурагчдад зөвлөгөө өгөх төв юм. CLB нь сургуулийн сурагч болон залууст тусламж үзүүлдэг.

Сургууль бүр CLB-тэй хамтарч ажилладаг. Гэхдээ CLB нь сургуулийн нэг хэсэг биш. Харин тусдаа байгууллага юм.

CLB нь **ямар ч үнэ төлбөргүй** зөвлөгөө тусламж үзүүлдэг.

### Та CLB-с юу асууж болох вэ?

- Сургуулиас үзүүлдэг тусламж, дэмжлэгийн талаар танд асуулт байна уу?
- Юу сурах эсвэл цаашид ямар ажил хийхийг хүсэж байгаа талаар танд тусламж хэрэгтэй юу?
- Танд сургууль дээр аливаа хэцүү асуудал байгаа юу? Та унших, бичихдээ тийм ч сайн биш үү? Сурахад хэцүү байна уу? Эсвэл хэт амархан байна уу? Анхаарлаа төвлөрүүлэхэд хэцүү байдаг уу? Хичээлээ хэрхэн сайн хийх талаар сайн мэдэхгүй байна уу?
- Танд гэртээ байхад хэцүү зүйл байдаг уу? Таныг хэн нэгэн дээрэлхдэг үү? Таны эцэг эх салсан уу? Найзуудтайгаа хэрхэн харилцахаа мэдэхгүй байна уу? Та маш их стрэсстэй байна уу?
- Та ямар ч найзгүй байна уу? Та өөртөө сэтгэл дундуур байдаг үү? Та гунигтай, ууртай, ганцаардмал гэх мэт таагүй мэдрэмжийг мэдэрдэг үү? Та тэр тухай яримаар байна уу?
- Та эрүүл мэндийнхээ талаар ямар нэгэн зүйл асуумаар байна уу? Тухайлбал: Миний өсөлт хэвийн байгаа болов уу? гэх мэт. Миний хараа болон сонсгол сайн байгаа болов уу? Би хэрхэн эрүүл хооллох вэ? Бэлгийн бойжилтын талаар? Тамхидалт, согтууруулах ундаа, тоглоом гэх мэт., Ингэх нь зүгээр үү? Үүний талаар би юу хийж чадах вэ?
- Гэх мэт бусад

CLB-с асуултаа асуугаарай!

Таны эцэг эх болон сургууль мөн CLB-д хандаж болно.

### CLB-с хэрхэн асуулт асуух вэ?



- Сургуулиараа дамжуулан асуух: CLB-тэй холбоо барих мэдээллийг сургуулиасаа авах Эсвэл <http://www.onderwijskiezer.be> цахим хуудсаар нэвтэрч
- [www.clbchat.be](http://www.clbchat.be)-р дамжин нэрээ нууцлан CLB-тэй үнэ төлбөргүй чаталж болно. Ажилтнууд нь танай сургуулийн CLB-д ажилладаггүй. Таны эцэг, эх мөн CLB-тэй чаталж болно.
- Та дунд сургуулийн сурагч бол [blinkers.clbonline.be](http://blinkers.clbonline.be) -р дамжин хандаж болох ба: сурагчийн ID дугаараа ашиглан нэвтэрнэ. Сурагчийн дугаарыг сургуулиасаа авна. Ийм байдлаар CLB-д шууд хандаж болно.  
Blinkers ашиглан асуулт асууж эсвэл уулзалтын хүсэлт илгээж болно. Та аливаа мэдээлэл олж авах болон өөрийн мэдээллийг шалгах боломжтой. Эцэг эхчүүд [www.burgerprofiel.be](http://www.burgerprofiel.be)-р дамжин Blinkers рүү нэвтэрнэ.
- [www.onderwijskiezer.be](http://www.onderwijskiezer.be)-с та ямар хичээл судлах, сурах зүйлсээ сонгох, суралцахад хэрэгтэй урам зориг, арга замуудын талаар мэдээлэл авах боломжтой.

### CLB хэрхэн ажилладаг вэ?

CLB-н ажилтнууд эхлээд тантай эсвэл таны эцэг эхтэй ярилцдаг. Та эсвэл эцэг эх тань хэн нэгнийг CLB рүү дагуулан ирж болно. Багш, найз, эгч, ах гэх мэт таны дотнын хүн байж болно.

CLB-ийн ажилтнууд:

- Таныг сонсож
- CLB хэрхэн ажилладаг талаар танд тайлбарлаж
- таны асуудлыг шийдвэрлэхээр таны төлөө ажилладаг.

Сэтгэлзүйч, багш, эмч, нийгмийн ажилтан, сувилагч гэх мэт олон төрлийн мэргэжлийн ажилтнууд CLB-д ажилладаг Тэдгээр хүмүүс танд хэрхэн илүү сайн туслах талаар хэлэлцэж, хамтран ажилладаг.

CLB нь таныг тодорхой хугацаанд хүрэлцэн ирэхийг урина. Үүнийг "системтэйгээр уулзах үе" гэдэг. Энэхүү уулзалт нь таныг бага сургуулийн нэгдүгээр ангиас дунд сургуулийн зургаа дугаар анги хүртэлх хугацаанд 5 удаа хийгдэнэ. Бага сургуулийн сурагчдыг эцэг эх нь дагалдан ирнэ. CLB нь таны өсөлт, хөгжлийг хянадаг.

Мөн CLB нь бага сургуулийн 4-р ангийн сурагчдад улаан бурхан, гахайн хавдар, улаан эсэргэнэ гэх мэт өвчнөөс сэргийлэх вакциныг үнэ төлбөргүй хийж өгөх боломжтой. Эхлээд тайлбар мэдээлэл өгнө. Та болон таны эцэг эх өөрсдөө шийдвэрээ гаргана. Мөн та асуулт асуух боломжтой.

CLB-д ажилладаг хэн боловч **нууц хадгалах мэргэжлийн ёс зүйг** баримталдаг. Хэрэв та CLB-д ажилладаг хэн нэгэнд ямар нэг зүйлийг хэлсэн бол тэр хүн үүнийг өөр хэнд ч хэлэхгүй байх үүрэгтэй.

Заримдаа CLB нь таны эцэг эх, сургууль болон нийгмийн ажилтантай хамтран ажилладаг. Ингэснээр танд илүү сайн тусалж чадна. CLB нь хамгийн эхэнд тантай ярилцдаг.

Та үнэхээр аюулд өртсөн байна уу? Тийм бол CLB-ийн ажилтнууд нь нууц хадгалах мэргэжлийн ёс зүйгээ мөрдөхгүй байж болно. Дахин хэлэхэд, CLB-ийн ажилтнууд энэ талаар хамгийн түрүүнд тантай ярилцана.

Нууц хадгалах мэргэжлийн ёс зүйн талаар танд асуулт байна уу? CLB-ийн ажилтнуудаас асуугаарай.